



# ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



[www.audit.mn](http://www.audit.mn)

[tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn)

## 2020 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



ЗУУНМОД



Товчилсон үг	Товчилсон үгийн тайлбар
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АХЭДСЗ	Аймгийн хөдөлмөр эрхлэгчдийг дэмжих сангийн зөвлөл
ҮАГ	Үндэсний аудитын газар
НАГ	Нийцлийн аудитын газар
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
ГЗБТ	Газар зохион байгуулалтын төлөвлөгөө
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ДЭХГ	Дулааны эрчим хүчний газар
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг газар
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ИТХТ	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгч
ММНБИ	Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт
МНБ	Мэргэшсэн нягтлан бодогч
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
ОНӨААНҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
СТАУС	Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын систем
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ТАЗ	Төрийн албаны зөвлөл
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТӨӨЗ	Тендерт оролцогчдын өгөгдлийн зааварчилгаа
УИХ	Улсын их хурал
ҮАБ	Үндэсний аюулгүй байдал
ҮАБЗ	Үндэсний аюулгүй байдлын зөвлөл
ЧХ	Чанарын хяналт
ҮХЭХ	Үл хөдлөх эд хөрөнгө
ҮХЭХАТ	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар
ХАК	Хувийн аудитын компани
ХАСХОМ	Хувийн ашиг сонирхлын хөрөнгө орлогын мэдүүлэг
АТГ	Авилагтай тэмцэх газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХЭДС	Хөдөлмөр эрхлэгчдийг дэмжих сан
ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар
МЭГ	Мал эмнэлгийн газар
ХШҮДАА	Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын алба
ХЭЗХ	Хууль, эрх зүйн хэлтэс
ЦГ	Цагдаагийн газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



## ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН 2020 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2020 оны 06 дугаар сарын 30

Зуунмод

### Нэг. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР:

Төв аймаг дахь Төрийн аудитын газар нь 2020 оны эхний хагас жилд Төрийн аудитын тухай хууль /06 дүгээр сарын 1-ээс шинэчлэн найруулсан хуулийг/, болон холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгон аудитын олон улсын стандартын хүрээнд аудитын болон үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Удирдлага зохион байгуулалтын хувьд Санхүүгийн, Нийцлийн, Гүйцэтгэлийн аудитын багт хуваагдаж тус бүр нэг ахлах аудитор, 2 аудитортой 3-н хүний бүрэлдэхүүнтэйгээр 3-н баг ажиллаж байна. Нийтлэг үйлчилгээний албанд жолооч, нягтлан бодогч-бичиг хэргийн ажилтан хамрагдаж байна. Мөн дарга, тэргүүлэх аудиторын дэргэд Удирдлагын зөвлөл үйл ажиллагаа явуулж байна.

### Хоёр. САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЛААР:

#### 2.1 Санхүүгийн тайлангийн аудит


Төв аймаг дахь Төрийн аудитын газар нь хуулиар тодорхойлогдсон чиг үүргийнхээ дагуу санхүүгийн тайлангийн аудитыг Төрийн аудитын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд аудитын олон улсын стандарт, санхүүгийн тайланд аудит хийх журмын дагуу төлөвлөлтийн өмнөх, төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагнал, тайлагналын дараах гэсэн таван үе шатаар СТАУС программыг ашиглан гүйцэтгэлээ.

2019 оны санхүүгийн тайлангийн аудитад 370 санхүүгийн тайлан хамрагдсанаас шууд захирагчийн 10 санхүүгийн тайланд итгэл үзүүлж, төсвийн байгууллага, тусгай зориулалтын сангуудын 169 санхүүгийн тайланг, 1 орон нутгийн өмчит хуулийн этгээд нь санхүүгийн тайландаа аудит хийлгээгүй тул 190 байгууллагад бие даан аудит хийж, санал дүгнэлт гаргасан.

Нийт санхүүгийн тайлангийн 69.7 хувь буюу 258 санхүүгийн тайланд Төрийн аудитын газрын аудиторууд буюу гэрээт аудитор аудит хийж, нэг аудитор дунджаар 23-27 санхүүгийн тайланд аудит хийсэн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5-д “Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайланд аудит хийх чиг үүргээ аудитын бусад байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно” гэж заасны дагуу 112 санхүүгийн тайланд буюу 30,3 хувийг гэрээний үндсэн дээр ХАК-аар гүйцэтгүүллээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 51,149.8 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 119.7 сая төгрөгийн төлбөрийн акт бичигдсэнээс 101.6 сая төгрөгийг барагдуулж, биелэлт 84,8 хувь, 11,741.2 сая төгрөгийн албан шаардлага өгснөөс







6,900.2 сая төгрөгийн зөрчлийг арилган, биелэлт 58,7 хувь, 19,383.1 сая төгрөгийн 563 зөвлөмжийг 87,7 хувь бүрэн хэрэгжүүлэн ажиллалаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийт алдаа зөрчил нь өмнөх оноос 27,629.7 сая төгрөгөөр буюу 35,1 хувиар буурсан, төлбөрийн акт 38,0 хувиар, албан шаардлага 44,9 хувиар тус тус буурсан эерэг үзүүлэлттэй байна. Энэ нь өмнөх онуудад өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмж нь тодорхой үр дүнтэй хэрэгжсэнийг харуулж байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар төсөвт оруулсан төлбөрийн актын дүнгээр 101.6 сая төгрөгийн үр өгөөжийг тооцлоо.

### **2.1.1 Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийлээ.

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, нэгтгэх үйл ажиллагаанд Засгийн газрын төсвийн гүйцэтгэлийн Э-тайлангийн программыг ашиглаж байна.

ТЕЗ-ийн 2019 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 386.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь гүйцэтгэлийн шатанд дахин тооцсон материаллаг байдлын түвшнээс бага тул “Зөрчилгүй” санал дүгнэлт өгч, удирдлагад 3 зөвлөмж хүргүүллээ.

Аймгийн ИТХТ-ийн 2020 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаар ТЕЗ-ийн 2019 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайланг дүгнэлтийг танилцуулж, тэргүүлэгчдээс гарсан асуултуудад тодорхой хариултуудыг өгсөн ба аймгийн ИТХ-ийн 2020 оны 07 дугаар сарын 02-ний өдрийн хуралдаанд танилцуулахаар боллоо.

### **2.1.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн тайлангийн аудит**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасан дагуу Төсвийн төвлөрүүлэн захирагчдын 2019 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийлээ.

Төсвийн төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн 28 тайланд аудит хийгдэж, санал дүгнэлт гаргаснаас 89,2 хувь буюу 25 тайланд “Зөрчилгүй”, 10,8 хувь буюу 3 тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгөгдлөө. Аудитаар нийт 2,457.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1,259.9 сая төгрөгийн алдааг залруулж, 2.0 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 278.4 сая төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага хүргүүлж, 917.3 сая төгрөгийн алдаа, зөрчилд 48 зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

### **2.1.3 Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудит**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайланд аудит хийлээ.

Төсвийн шууд захирагчийн 215 санхүүгийн тайлангаас 10 байгууллагын санхүүгийн тайланд итгэл үзүүлж, 55 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулан, байгууллагын үйл ажиллагаа нь зогссоноос 1 байгууллага аудитад хамрагдаагүй, 149 байгууллагын санхүүгийн тайланд санал дүгнэлт гаргалаа. Үүнд:



Санал дүгнэлт гаргасан ТШЗ-ийн 149 санхүүгийн тайлангийн 89,9 хувь буюу 134 санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 9,4 хувь буюу 14 санхүүгийн тайланд “Хязгаарлалттай”, 1 санхүүгийн тайланд “Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан” санал дүгнэлт өгөгдлөө.

Аудитаар нийт 39,789.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 11499.3 сая төгрөгийн алдааг залруулж, 110.5 сая төгрөгийн зөрчилд 66 төлбөрийн акт тогтоож, 10,927.3 сая төгрөгийн зөрчилд 196 албан шаардлага, 86.1 сая төгрөгийн алдаа, зөрчил гаргасан 20 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлж, 58.7 сая төгрөгийн 2 асуудлыг шалгуулахаар хууль, хяналтын байгууллагад шилжүүлж, 17,109.7 сая төгрөгийн алдаа, зөрчилд 491 зөвлөмж өгч, хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

#### **2.1.4 Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн аудит**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-т заасны дагуу Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгууллагын 9 санхүүгийн тайланд аудит хийхээс Томоко ОНӨААТҮГ нь татан буугдсан тул аудитад хамрагдаагүй тул 8 санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргалаа. Үүнд: Зуунмод сум дахь Мах боловсруулах үйлдвэр “Сөрөг”, Баянчандмань АЗЗА “Хязгаарлалттай”, бусад 7 байгууллага Зөрчилгүй санал дүгнэлт өгөгдлөө. Аудитаар 7.3 сая төгрөгийн 5 төлбөрийн акт, 535.5 сая төгрөгийн 6 албан шаардлага өгч, 640.7 сая төгрөгийн 18 зөвлөмж өгч, хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

#### **2.1.5 Завсрын аудит**

Завсрын аудитаар 14 сумын төсөвт байгууллагууд болон аймгийн төвийн 29 байгууллагын санхүүгийн тайланг хамруулахаар төлөвлөж, Төрийн жинхэнэ албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдан батлагдсан. Аудиторууд нь хариуцсан байгууллагуудад Завсрын аудит хийх аудитын төлөвлөгөөг боловсруулсан боловч, 2020 оны ээлжит сонгуулиудтай холбоотой, хуулийн хугацаанд багтааж нийцэл, гүйцэтгэлийн аудитууд хийгдэж буй тул хүний нөөцийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалан зарим завсрын аудит төлөвлөсөн хугацаанд хийгдээгүй байна.

### **Гурав. ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЛААР:**

Монгол улсын Ерөнхий аудиторын “Аудитын төлөвлөгөө батлах тухай” 2019 оны 12 дугаар сарын 12-ний А/100 дугаар тушаалаар батлагдсан 2019 онд ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар гүйцэтгэх аудитын төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлийн 3, өөрийн санаачилгаар 2, бүгд 5 гүйцэтгэлийн аудитыг хийхээр байгууллагын болон Төрийн жинхэнэ албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан. Монгол улсын Ерөнхий аудиторын “Аудитын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” 2020 оны А/53 дугаар тушаалаар аймаг, сумын ИТХ-ын сонгууль зохион байгуулахтайгаар 1 аудит нэмэгдсэн байна.

Эхний хагас жилийн байдлаар нийт 6 гүйцэтгэлийн аудитаас 2 аудитыг бүрэн гүйцэтгэсэн, 1 аудитын хугацаа ҮАГ-аас хойшлуулсан ба 3 аудит хугацаа болоогүй байна.



**3.1. “Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө” /ГАГ-2020/02/-ГА/**



Аудитын талбарын ажлыг 2020 оны 2 дугаар сарын 14-ний өдрөөс 2020 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр хүртэл гүйцэтгэж, холбогдох байгууллагын саналыг авч, аудитын тайлан, судалгааг 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр ҮАГ-т хүргүүлээ.

“Монгол улсын 2019 оны төсвийн тухай” хуулиар Төв аймагт есөн<sup>1</sup> сайдын багцад 106,752.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 50 хөрөнгө оруулалтын ажлын 38,171.6 сая төгрөгийн санхүүжилт батлагдан хэрэгжсэн байна. Үүнээс 21,228.6 сая төгрөгийн төсөвт

өртөгтэй 22 ажил 2018-2019 он дамжин хэрэгжиж, 85,523.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 28 ажил шинээр хэрэгжихээр батлагдсан байна.

Шинээр хэрэгжүүлэхээр батлагдсан хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнүүд нь “2016-2020 онд Төв аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” болон “Аймгийн эдийн засаг нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлтэй” уялдсан байна.

Шинээр хэрэгжих 85,523.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 28 хөрөнгө оруулалтын ажлыг мөнгөн дүнгээр авч үзвэл 75.0 хувь нь дэд бүтцийн салбарын барилга, байгууламж байна. Харин тооны хувьд дийлэнх хувь буюу 60 хувь нь нийгмийн салбарт хэрэгжих барилга, байгууламжууд батлагдсан байна.

Тус аудитаар нийт 15,121.1 сая төгрөгийн 15 зөрчил илэрсний 79.8 сая төгрөгийн 6 зөрчилд акт бичигдэж биелэлт 100 хувьтай, 15,041.3 сая төгрөгийн 9 зөрчилд албан шаардлага бичигдсэнээс 125.5 сая төгрөгийн 3 албан шаардлага хэрэгжиж, үлдсэн 14,915.8 сая төгрөгийн 6 албан шаардлагын хэрэгжилт хугацаа болоогүй байна.

**3.2. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүн /ТӨА-2020/0/-ГА/**



ҮАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газарт 2020.01.20-ний өдрийн 01/30 тоот албан бичгээр Төв аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа Төрийн өмчийн сургуулиудын 2016-2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн дүгнэлт, илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл болон шинээр ашиглалтад орсон барилга байгууламжийн судалгааг маягтын дагуу гаргаж хүргүүлсэн. ҮАГ-аас уг аудитын хугацааг хойшлуулсан байгаа.

<sup>1</sup> Аймагт хэрэгжсэн нийт 9 сайдын багцад эрх шилжээгүй ХО-ын ажлыг аймгийн ХОХБТ-ийн хэлтсээс ирүүлсэн судалгаан дээр үндэслэсэн оруулсан болно.



### 3.3. Орон нутгийн төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүн, үр ашиг /ТӨА-2020/05/-ГА/



Аудитыг УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2019 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын "Аудитын төлөвлөгөө батлах тухай" 2019 оны А/100 дугаар тушаалаар батлагдсан сэдвийн дагуу, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д заасан бүрэн эрхийн хүрээнд 2020 оны 4 дугаар сарын 20-ний өдрөөс 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдөр хүртэл гүйцэтгэлээ. Аудитын тайлан, холбогдох судалгаа, мэдээллийг холбогдох байгууллага албан тушаалтанд хугацаанд нь хүргүүлсэн. Аудитын тайланг аймгийн ИТХТ-ийн 2020 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанд танилцуулан хэлэлцүүлээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 4 эх үүсвэрээс хөрөнгө оруулалтын 68 төсөл арга хэмжээнд 7,137.8 сая төгрөгийг санхүүжүүлэхээр баталсан байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудын аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, 2019 оны үндсэн чиглэлд тусгагдсан байдлыг авч үзэхэд нийт хөрөнгө оруулалтын чанартай 68 арга хэмжээнээс 54 арга хэмжээ аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, 2019 оны үндсэн чиглэлд тусгагдсан 14 арга хэмжээ тусгагдаагүй байна.

Энэ нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4-д Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд үндэслэн тухайн жилийн төсвийн төслийг боловсруулна гэснийг зөрчсөн байна.

Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан Үнэлгээний хороод ХАА-г зохион байгуулахдаа ТБОНӨХБАҮХА тухай хууль, Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ"-ийг баримтлан ажилласан байна. 2019 онд бүх тендерийг цахимаар зохион байгуулж оролцогчдыг ил тод, өрсөлдөх тэгш боломжоор хангасан байна.

ОНХС, Шилжих үлдэгдэл, БХОНСАХЗардал, Замын сангийн эх үүсвэрээр 2019 онд нийт 68 хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 56 хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ хэрэгжиж ашиглалтанд хүлээн авсан.

Аудитаар илэрсэн зөрчилд 2,459.1 сая төгрөгийн албан шаардлага, 3,9 сая төгрөгийн акт бичиж, аудитын тайланг баталгаажуулан холбогдох байгууллагад хүргүүлээ.

#### Дөрөв. НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЛААР:

Монгол улсын Ерөнхий аудиторын "Аудитын төлөвлөгөө батлах тухай" 2019 оны 12 дугаар сарын 12-ний А/100 дугаар тушаалаар батлагдсан 2019 онд ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар гүйцэтгэх аудитын төлөвлөгөөний дагуу 5, аймгийн ИТХ-ын захиалгаар гүйцэтгэх 2, бүгд 7 нийцлийн аудитыг хийхээр байгууллагын болон Төрийн жинхэнэ албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган ажиллалаа.

Эхний хагас жилийн байдлаар 3 аудитыг бүрэн гүйцэтгэсэн, 2 аудит гүйцэтгэлийн үе шатандаа явагдаж байгаа ба ОНХС-ийн 2019 оны хөрөнгийн зарцуулалт сэдэвт аудитыг санхүүгийн тайлангийн аудитын явцад дэд төлөвлөгөө боловсруулан гүйцэтгэсэн ба 1 аудит хугацаа болоогүй байна.





#### 4.1. “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт” /ҮАГ-НАГ-2020/01-НА/



Аудитыг НАГ-ын нэгдсэн удирдамж, төлөвлөгөөний дагуу 2020 оны 01 дугаар сарын 10-аас 05 дугаар сарын 15-ыг хүртэлх хугацаанд хийх ба санхүүгийн тайлангийн аудитын явцад судалгаа материалыг цуглуулан гүйцэтгэж, тайланг ҮАГ-ын Нийцлийн аудитын газар, холбогдох газруудад хүргүүллээ.

Тус аудитаар шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-3.1.2 дахь хэсэгт заасан төрийн байгууллагыг тус хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 -д заасны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчдаас хэрэгжүүлж буй дотоод хяналтын дүн

мэдээнд үндэслэн орон нутгийн төсвийн 231 байгууллагыг хамруулан, 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуусталх хугацааны шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг дүгнэлээ.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасан хяналтын багц буюу түүнээс дээш хувийг төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа нийт 9 байгууллагаас 8 байгууллага шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг байршуулж, Төв Эрдэнэс ОНӨААТҮГ нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд эрх нээлгэж мэдээллээ шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.8-д заасан мэдээллийг 7 хоногийн дотор мэдээлнэ гэсний дагуу байршуулаагүй байна.

Аудитаар 9 сумдын эргэлтийн эмийн сан ажил гүйлгээг цахим хуудас нээж байршуулаагүй байгаа зөрчилд 10 албан шаардлага, 4 зөвлөмж өгч хэрэгжилтийг тооцон ажиллаж байна

#### 4.2 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн /НАГ-2020/02-НА/



Аудитыг НАГ-ын нэгдсэн удирдамж, төлөвлөгөөний дагуу 2020 оны 9 дүгээр сард гүйцэтгэхээр тусгагдсан байна.

Аудитын бэлтгэл ажлын хүрээнд санхүүгийн тайлангийн аудитын явцад дэд төлөвлөгөө боловсруулан ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажилд 4 горим сорил хэрэгжүүлж, мэдээллийг СТАУС программд бүрэн орууллаа. Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэлийг байгууллагад танилцуулан илэрсэн зөрчилд нийт

8.3 сая төгрөгийн 4 төлбөрийн акт, 540.2 сая төгрөгийн 11 албан шаардлага, 98.2 сая төгрөгийн 3 зөрчилд албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага бичиж, хэрэгжилтийг тооцон ажиллаж байна. 2020 оны 6 дүгээр сарын 26-ны өдөр НАГ-аас ирүүлсэн аудитын төлөвлөгөө, судалгаа, хавсралт маягтуудад санал авах чиглэлийн дагуу холбогдох саналыг хүргүүлсэн болно.





**4.3. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн хэрэгжилт /ТӨА-2020/07/-НА/**



Аудитыг аймгийн ИТХ-ын захиалгаар Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилсан сэргийлэх хөтөлбөрийн хэрэгжилт /2016-2019/ сэдэвт нийцлийн аудитыг 2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөс 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд хийгдэхээр аудитын төлөвлөгөөг боловсруулан баталж, холбогдох байгууллагын удирдлага, мэргэжилтнүүдийг оролцон аудитын нээлтийг хийлээ.

Аудитад аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ, ХШУДАА, ХХААГ, МЭГ, ЦГ, сумд зэрэг нийт 30 байгууллага хамрагдлаа. Аймгийн ИТХ-с 2015 оны 12 дугаар сард “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хөтөлбөр”-ийг 2016-2019 оны хооронд буюу 4 жилийн хугацаанд жил бүр төлөвлөгөө боловсруулан хийж гүйцэтгэхээр баталсан байна. Хөтөлбөрийн хэрэгжилтийг 2020 оны 03 дугаар сарын 12-ны өдөр 91 хувьтай буюу “Үр дүнтэй” хэрэгжсэн гэж дүгнэж, цаашид “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө /2020-2022/-г баталж ажиллаж байна.

Аудитын хүрээнд холбогдох хамрагдагч байгууллагуудаас ирүүлсэн тайлан, судалгаа, холбогдох баримт материалуудыг хөтөлбөрийн хэрэгжилттэй тулган баталгаажуулахад хөтөлбөрийн хэрэгжилтийг 91 хувьтай буюу “Үр дүнтэй” хэрэгжсэн гэж үнэлсэн нь бодитой байдалтай нийцэхгүй, хэт өндрөөр дүгнэсэн байна гэж үзлээ. Учир нь аймгийн хэмжээний мал хулгайлах гэмт хэргийн гаралт буураагүй, илрүүлэлт өсөөгүй, шүүхээс энэ төрлийн гэмт хэрэгт ял шийтгүүлсэн иргэд болон хохирлын тоо нэмэгдсээр байна. Мөн түүнчлэн сумдын хууль эрх зүйн мэргэжилтнүүдийн тогтвор суурьшилгүй байдал, ажил хүлээлцдэггүй, баримт материалыг архивладаггүй зэргээс зарим сумдын баримт материал байхгүй гэх тайлбарыг сумын Засаг дарга нар албан бичгээр мэдэгдсэн, мөн сумдаас баримт материалыг шаардсан хугацаанд нь аудитад ирүүлэхгүй, хугацаа алдсан нь аудитын явцад хүндрэл бэрхшээл учрууллаа.

Аудитын тайланг боловсруулан холбогдох байгууллагаас санал авахаар илгээгээд байна.

**4.4. Аймаг, нийслэл, сум дүүрэг дэх орон нутгийн сонгуулийн тойрогт нам, эвсэл, нар дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох /ТӨА-2020/03/-НА/**



Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6.3-д заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/52 дугаар аргачлалын дагуу дүн шинжилгээ хийх төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулан батлуулж гүйцэтгэлээ.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-д “энэ хуульд нийцүүлэн төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх сонгуулийн



*тойрогт нам, эвсэл болон нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг ээлжит сонгуулийн жилийн 7 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө тогтоож, нийтэд мэдээлнэ”* гэж заасны дагуу зардлын дээд хэмжээг тогтоож улс төрийн намуудад сонсох ажиллагаа зохион байгуулан танилцууллаа.

Зардлын дээд хэмжээг тогтоохдоо тооцоолохын өмнө хийх урьдчилсан судалгаанд дүн шинжилгээ хийж, аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нам, эвслээс зарцуулах зардлын дээд хэмжээг аймагт 511.9 сая төгрөгөөр, сумдад 341.3 сая төгрөгөөр тогтоож, нэг тойрогт зарцуулах зардлын дээд хэмжээг хавсралтаар гарган нийтэд мэдээллээ.

**4.5 Орон нутгийн Хурлын ээлжит сонгуулийн жилийн 06 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд тухайн нам, иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивыг хянаж, баталгаажуулах /ТӨА-2020/08/-НА/**



Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны ээлжит сонгуульд нам, эвслээс ирүүлсэн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргах аудитын төлөвлөгөөг батлуулан ажиллаж байна.

Батлагдсан төлөвлөгөөний дагуу Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37.7-д “*Нам, эвсэл нь орон нутгийн Хурлын ээлжит сонгуулийн жилийн 06 дугаар сарын 25-ны өдрөөс өмнө энэ хуулийн 25.3.6, 25.4.6-д заасан*

*хандивын тайландаа дүгнэлт гаргуулахаар төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ”* гэж заасны дагуу нийт 10 намаас 35 хандивын тайланг ирүүлээд байна.

Нам, эвслээс ирүүлсэн хандивын тайлантай холбогдуулан дансны хуулгаар гарсан хандивын орлогыг тулган баталгаажуулах ажиллагаа хийгдэж байна

**4.6 Орон нутгийн 2020 оны ээлжит сонгуульд оролцох улс төрийн нам эвсэл, бие даан нэр дэвшигчдийн сонгуулийн мөрийн хөтөлбөр, эдийн засгийн тооцоо судалгаанд дүгнэлт гаргах /ТӨА-2020/05/-НА/**



МУЕА-ын 2020 оны 06 дугаар сарын 16-ний өдрийн “Аргачлал батлах тухай” А/56 тоот тушаалын дагуу орон нутгийн 2020 оны ээлжит сонгуульд оролцох улс төрийн нам эвсэл, бие даан нэр дэвшигчдийн сонгуулийн мөрийн хөтөлбөр, эдийн засгийн тооцоо судалгаанд дүгнэлт гаргах аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулан батлууллаа. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай

хуулийн 37.6-д “*Нам, эвсэл нь орон нутгийн Хурлын ээлжит сонгуулийн жилийн 06 дугаар сарын 25-ны өдрөөс өмнө ... сонгуулийн мөрийн хөтөлбөртөө дүгнэлт гаргуулахаар төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ”* гэж заасны дагуу 2020.06.24-ний өдөр улс төрийн намуудын мөрийн хөтөлбөрийг “Улс төрийн нам эвсэл, бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт



аудит хийх, дүгнэлт гаргахад мэдээллийг нууцлах, хамгаалах журам"-ын дагуу бүртгэлийг хөтлөн хүлээн авлаа.


2020 оны 6-р сарын 26-ны байдлаар 10 намаас аймгийн ИТХ-н сонгуульд оролцох мөрийн хөтөлбөр ирлүүлснийг журмын дагуу гүйцэтгэх аудиторуудад хуваарилан, гүйцэтгэлийн шатны горимыг хэрэгжүүлж байна.

**Тав. ДОТООД АЖЛЫН ТАЛААР:**

**5.1. Хүний нөөцийн талаар:**

Манай байгууллага нь 2020 онд батлагдсан орон тооны дагуу үндсэн 12 ажилтан, гэрээт 1 ажилтан нийт 13 ажиллагсадтайгаар үйл ажиллагаа явуулж байна. Үүнд: Дарга, тэргүүлэх аудитор, хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер, ахлах аудитор 3, аудитор 6, жолооч, нягтлан бодогч бөгөөд бичиг хэргийн ажилтан ажиллаж байна.

Нийт албан хаагчид мэргэжлийн хувьд 9 нь нягтлан бодогч буюу Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогч, 1 эдийн засагч мэргэжилтэй, 1 хуульч мэргэжилтэй аудиторууд ажиллаж байна.



Албан хаагчдын ажлын туршлагын хувьд Төрийн аудитын байгууллагад 5 хүртэл жил ажилласан 35,7 хувь, 6-10 жил ажилласан 7,1 хувь, 11-15 жил ажилласан 42,9 хувь, 16-аас дээш жил ажилласан нь 14,3 хувь тус тус эзэлж байна.

Албан хаагчдын 42,9 хувь нь 25-40 насныхан, 57,1 хувь нь 41-ээс дээш насныхан, ба хүйсийн харьцаа 35,7 хувь нь эрэгтэй, 64,3 хувь нь эмэгтэй байна.

Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер О.Амаржаргал нь хүүхэд асрах чөлөөтэй тул ахлах аудитор Т.Майцэцэг аудитын менежерийн албан үүргийг, аудитор Ц.Саранчимэг санхүүгийн тайлангийн аудитын ахлах аудиторын үүргийг түр орлон гүйцэтгэх тухай МУЕА-ын тушаалаар томилгоо хийгдсэн болно.

2019 оны санхүүгийн тайланд аудит хийх хүний нөөц хүрэлцээгүй тул Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцэн санхүүгийн тайлангийн аудитад О.Сосор, Б.Нямсүрэн нарыг 2020 оны 01 дүгээр сарын 22-ний өдрөөс 04 дугаар сарын 25-ны өдрийг дуусталх хугацаанд гэрээгээр авч ажиллууллаа.

Аудитор А.Батлхагва өвчний улмаас чөлөө авсантай холбогдуулан оронд нь нягтлан бодогч бичиг хэргийн ажилтан Т.Хүрэлбаатарыг МУЕА-ын тушаалаар томилсон ба бичиг хэргийн ажилтанг гэрээгээр ажиллуулж байна.

Засгийн газрын 2019 оны 38 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшин үнэлэх журам”, МУЕА-ын 2020.02.18-ний өдрийн “Журам батлах тухай” А/20 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан “Төрийн аудитын байгууллагын Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг





боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшин үнэлэх журам” зэргийг үндэслэн байгууллагын Төрийн жинхэнэ албан хаагчидтай гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулан, хэрэгжилтийг улирал бүрээр гаргуулан, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Албан хаагчдын үндсэн цалинг МУЕА-ын 2020 оны А/04 дүгээр тушаалын дагуу тооцон олгож байгаа ба зэрэг дэвийн нэмэгдлээс бусад нэмэгдэл болон гэрээт ажилчдын цалинг дарга, тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан албан хаагчдын цалинг цаг тухайд нь бүрэн олгож байна.

Төрийн аудитын байгууллагад болон төрийн албанд ажилласан ажлын амжилтыг нь үнэлэн Улсын баяр наадмыг тохиолдуулан 5 ажилтныг шагнаж урамшуулахаар анкет тодорхойлолтыг ҮАГ-т уламжлаад байна.

Төрийн аудитын байгууллагын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг мөрдөж ажиллах хүрээнд аудиторууд чөлөөт цагаар олон нийтийн арга хэмжээнд болон бусад байгууллагаас зохиогдсон уралдаан тэмцээнд амжилттай оролцлоо.



Монгол улсын шинэ үндсэн хууль батлагдсаны 28 жилийн ойг тохиолдуулан Төр захиргааны 1, 2-р байрны албан хаагч, ажилчдын дунд 2020.01.10-11-ний өдрүүдэд зохион байгуулсан спортын тэмцээнд багаараа оролцон, 6 төрлийн тэмцээний нийлбэр дүнгээр дэд байр эзэлж, Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдлаа.

Мөн тэмцээний нээлтийн үйл ажиллагаа дээр Төв аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Саранчимэг нь Биеийн тамир, спортын газрын “Спортын алдар” тэмдгээр шагнагдлаа.

Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд ажиллагсдадаа амны хаалт маск, дархлааг дэмжих цацаргана зэрэгт төсвөөс 241.4 мянган төгрөг зарцуулсан. Мөн дархлааг дэмжих эрүүл мэндийг сайжруулах зорилгоор ажлын байрны дасгалын өдөр бүр тогтмол цагт хийж хэвшсэн ба ажилчдын цалингаас албан хаагчидтай зөвшилцсөнөөр тодорхой хэмжээний мөнгийг суутган хуримтлал үүсгэж, ажиллагсдын амралт, чөлөөт цагаа өнгөрөөх болон бусад арга хэмжээнд зарцуулж байна.

## 5.2. Дотоод ажил

Төрийн албаны тухай хуулийн 54, 55 дугаар зүйл заалт, Монгол улсын Засгийн газрын 2019 оны 37, 38 дугаар тогтоол, МУЕА-ын 2020.02.18-ний өдрийн “Журам батлах тухай” А/20 тоот тушаалыг үндэслэн байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 гүйцэтгэлийн зорилтын хүрээнд боловсруулан баталгаажуулсан ба Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг 10 албан хаагчидтай хийж, баталгаажуулан хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

2020 оны нэг, хоёрдугаар улирлын байдлаарх Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн тайлан, биелэлтийг гаргуулан, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, тайланг нэгтгэн гаргаж, ҮАГ-т албан тоотоор хүргүүлээд байна.

Байгууллагын ажилчдын шуурхай хуралдааныг 7 хоног бүрийн нэг дэх өдөр тогтмол хийж, долоо хоногийн ажлын гүйцэтгэлийг дүгнэж, төлөвлөгөөт ажлыг танилцуулж байна. ТАБ-ын хэмжээнд ашиглагдаж байгаа дотоод удирдлагын систем <https://able.audit.mn/> -ний ажил хэрэг цэсэд аудиторууд нь өдөр тутмын үйл





ажиллагааг тайлагнаж байгаа нь аудиторуудын гүйцэтгэсэн ажил нээлттэй, ил тод шилэн боллоо.

Удирдлагын зөвлөлийн хурлыг 4 удаа хийж 2020 оны санхүүгийн аудитын хуваарьт өөрчлөлт оруулах, гэрээт ажилтан ажиллуулах, санхүүгийн аудитын дүн, дүгнэлт, тайлбартай акт, албан шаардлага, хариуцлага тооцох албан шаардлага, гүйцэтгэлийн, нийцлийн аудитын тайлан болон ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг хэлэлцэн тэмдэглэл хөтөллөө.

Монгол улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/235 тоот тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны тайлан болон статистик мэдээг боловсруулж тайлагнах журам”-ын дагуу үйл ажиллагааны тайлан, үр дүнгийн статистик мэдээг боловсруулан нэгтгэж, ҮАГ-т эхний хагас жилийн байдлаар мэдээлж, тайлагналаа. Мөн улирал бүр статистик мэдээг нэгтгэн аймгийн Статистикийн хэлтэст хүргүүлээ.

Аудитын болон үйл ажиллагааны явцын мэдээллийг МУЕА-ын орон нутаг хариуцсан орлогчид сар бүрийн 25-ны өдөр хугацаанд нь хүргүүлж ажилласан.

Төв аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор нь Төрийн аудитын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд аудиттай холбоотой А тушаал 12, дотоод ажилтай холбоотой Б тушаал 11 нийт 23 тушаалыг хууль эрх зүйд нийцүүлэн гаргасан байна.

Тайлант хугацаанд санхүүгийн тайлангийн аудитаар бичигдсэн төлбөрийн акттай холбоотой 4 өргөдөл ирснийг Удирдлагын зөвлөлийн хуралдаанд танилцуулан шийдвэрлүүллээ. Хариутай бичиг 8 ирснээс бүгд хугацаандаа шийдвэрлэгдсэн байна.

Авлигын эсрэг хуулийн дагуу 4 албан тушаалтан ажил үүрэг өөрчлөгдөхтэй холбогдуулан хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг гаргасан. Мөн хуулийн дагуу 8 албан тушаалтнаас хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд нь гаргуулан, цахимаар мэдээлсэн. Аудитороор томилогдсон Т.Хүрэлбаатар томилогдсоноос хойш 30 хоногийн дотор ХАСХОМ-ийг гаргаж, тайланг АТГ-т илгээсэн.

Санхүү, гүйцэтгэл, нийцлийн аудит эхлэх тухай бүрд УИХ-ын хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын 4-р хавсралтын дагуу мэдэгдлийг аудиторуудаар гаргуулан баталгаажуулан ажиллалаа.



Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн хуралдаанаас КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх зорилтот өрхийн болон хөгжлийн хүүхдүүдэд туслах зорилгоор “Нэг байгууллага-нэг хүүхэд хөдөлгөөн”-ийг эрчимжүүлэн ажиллахыг албан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд уриалсан дагуу хөгжлийн бэрхшээлтэй 5 настай Б.Баатархүү хүүд Төрийн аудитын газрын хамт олноос амны хаалт, дархлаа дэмжих бүтээгдхүүний дэмжлэгийг үзүүлж, “НЭГ БАЙГУУЛЛАГА - НЭГ ХҮҮХЭД ХӨДӨЛГӨӨН”-д нэгдлээ.

"Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр"-ийг тохиолдуулан Төв аймгийн Зуунмод хотын захирагчийн 04 тоот албан даалгаврын дагуу хуваарилсан газарт 2020.05.05-ний өдөр Одонт хөтлийн цэцэрлэгт хүрээлэнд 41 модны, байгууллагын



гадна хашаанд 3 модны нүх ухаж, мөн байрны үүд хашлагыг сийрэгжүүлэн зүлэгжүүлэхэд хөрсийг бэлтгэн орчныг цэвэрлэв. Мод тарих ажиллагаанд аудиторуд идэвхтэй оролцов.



Төв аймгийн Зуунмод хотын захирагчийн 03 тоот албан даалгавар дагуу КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, нийтийн эзэмшлийн талбайд орчны цэвэрлэгээ, ариутгал халдваргүйтгэл хийх ажлын хүрээнд байгууллагын гадна орчны хог хаягдлыг 2 удаа цэвэрлэв.

### **5.3 Мэдээлэл технологи, ил тод байдлын талаар:**

Төв аймаг дахь Төрийн аудитын газар нь [www.audit.mn](http://www.audit.mn) веб сайт, дотоод мэдээллийн цахим санд цаг үеийн 15 мэдээлэл, санхүүгийн тайлангийн аудитын 121 тайланг ЯАГ-ын баталсан загварын дагуу бэлтгэж [audit.mn](http://audit.mn) цахим хаягт QR кодоор баталгаажуулан байршуулсан ба тайланг хэвлэж холбогдох албан тушаалтан удирдлагад хүргүүллээ. Ажиллагсад нь аудитын байгууллагын [able.audit.mn](http://able.audit.mn) болон аймгийн [intranet.gov.mn](http://intranet.gov.mn) дотоод удирдлагын системийг өдөр тутмын үйл ажиллагаандаа тогтмол ашиглаж, мэдээллийг авч, солилцож байна.

Төрийн аудитын цахим сургалт нэвтрүүлэх хүрээнд аудитад excel программ ашиглах чадварыг ахиулах, цахим сургалтын хөтөлбөр боловсруулах зорилготой тандалт судалгаанд оролцож, судалгааны үр дүнг ЯАГ-ын стратеги удирдлагын газарт хүргүүлсэн.

Байгууллагын санхүүгийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2020 оны эхний хагас жилийн байдлаар мэдээлбэл зохих 63 мэдээллийг 100% цаг хугацаанд нь бүрэн мэдээлсэн. Мөн мэдээлбэл зохих мэдээллүүдийг байгууллагын ил тодын самбарт цаг тухай бүр байршуулан ажиллалаа.

Ажиллагсдын программд Skype for Business программ болон видео хурлын “Zoom” программыг суулгаж туршилт холболтыг хийж техник тоног төхөөрөмжийн бүрэн байдлыг хангаж ажиллалаа.

Байгууллагын хэмжээнд дотоод сервер үүсгэн хэрэгцээтэй файлуудыг байршуулан, найдвартай байдлыг хадгалан ажилласан ба сервер компьютер ажиллахгүй болсныг засварлуулсан мөн бусад тоног төхөөрөмжид засвар үйлчилгээ хийлгэлээ. Компьютер, принтер тоног төхөөрөмжийн ашиглалтын паспортын эхийг бэлтгэн хэвлэлээ.

Тагнуулын ерөнхий газраас бүх аймаг дахь Төрийн байгууллагуудаас мэдээллийн аюулгүй байдал, байгууллагад ашиглагдаж байгаа компьютер, техник хангамж, интернэт сүлжээний хурд, цахим хаяг, цахим орчинд мэдээлэл түгээх арга хэлбэрийн талаарх судалгааг хүргүүллээ.

Санхүү, гүйцэтгэл, нийцлийн аудитын тайланг 406 тоогоор хувилан олшруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд тухай бүрд хүргүүллээ.

Үндэсний аудитын газраас ирүүлсэн албан бичгийн дагуу шаардлагатай мэдээ, судалгааг гарган хугацаанд нь цахимаар болон бичгээр хүргүүлж ажиллалаа.

Төсвийн тухай хуульд заагдсан хугацаанд төсөв захирагчдын 2019 оны санхүүгийн тайлангийн аудитыг Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын систем (СТАУС-2) программыг болон аудитор Ж.Бямбацогтын боловсруулсан Excel-ийн загвар программыг санхүүгийн тайлангийн аудитын гүйцэтгэлийн үе



шатны ажилд байгууллагын хэмжээнд ашиглаж гүйцэтгэлээ. Төрийн аудитын байгууллагын СТАУС-2 программ нь санхүүгийн тайлангийн аудитад бүрэн ашиглагдаж, аудиторуудын ажлын ачааллыг хөнгөвчилж буй тул уг программын сүлжээний өргөтгөл, хөгжүүлэлтийг шийдвэрлүүлэх саналыг хүргүүлээ.

#### **5.4. Чанарын хяналтын талаар:**

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/221 дүгээр тушаалаар баталсан “Чанарын хяналтын журам”-ын дагуу 2020 оны эхний хагас жилийн байдлаар гүйцэтгэсэн 3 нийцлийн аудит, 2 гүйцэтгэлийн аудитын үе шат бүрд гурван шатны хяналтыг хэрэгжүүлж, хяналтын хуудас ЧХ-1, ЧХ-2, ЧХ-3 маягтуудыг хөтөлж чанарын хяналтыг хэрэгжүүллээ.

2020 онд гүйцэтгэсэн нийт 370 санхүүгийн тайлангийн аудитыг СТАУС программаар хийж, бүх үе шатны ажлыг 2 ахлах аудитор, 4 аудитор, 2 гэрээт ажилтан, 3 ХАК хэрэгжүүлж, аудитын менежер, тэргүүлэх аудитор нар хоёр шатны хяналтыг гүйцэтгэн шаардлагатай зөвлөмжийг өгч ажиллаа.

Аудитын тайлангуудын агуулга, чанарыг сайжруулахын тулд бүх шатанд анхаарлаа хандуулан долоо хоног бүрийн шуурхай дээр аудитын явцтай танилцаж, үүрэг чиглэл өгч ажилласан. Гэвч хүний нөөц, цаг хугацааны хүрэлцээгүй байдал, нэг аудиторт ногдох санхүүгийн тайлангийн тоо зэрэг нь аудитын чанарт нөлөөлөх эрсдэлтэй байна.

МУЕА-ын 2018 оны А/64 дүгээр тушаалаар батлагдсан “Хараат бус аудитын хуулийн этгээдийн хийсэн санхүүгийн тайлангийн аудитын ажлын гүйцэтгэлийг үнэлэх, тайлагнах заавар, аргачлал”-ын дагуу гэрээт гурван аудитын компанийн ажлын гүйцэтгэлийг үнэлэхэд, Дундманхайдай Аудит ХХК, Их монгол хөлөг Аудит ХХК тус бүр 85 оноо авч, гэрээний үүргээ бүрэн биелүүлсэн тул гэрээг сунган ажиллах, Уваа-Уул Аудит ХХК тус бүр 65 оноотой дүгнэгдсэн тул гэрээг цуцлах тухай шийдвэрлэлээ.

#### **5.5. Сургалтын талаар**

Төрийн аудитын байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөнд дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал оролцсон.

ҮАГ нь Удирдлагын академитай хамтран ажиллах төлөвлөгөөний хүрээнд “Ахлах түшмэлийн мэргэшүүлэх” зайн сургалтад дарга, Тэргүүлэх аудитор 3-р сард, ахлах түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалтныг мэргэшүүлэх багц сургалтад 4 ахлах аудитор зайн хэлбэрээр хамрагдан, шалгалтыг цахимаар өгч тэнцэн, гүйцэтгэх даалгаврыг сэдвийн дагуу бэлтгэн хүргүүлж, сертификат авлаа.

МУЕА-ын 2020.03.16-ны өдрийн А/30 дугаар тушаалаар Төрийн аудитын байгууллагын 2020 оны сургалтын чиглэл, ерөнхий төлөвлөгөө батлагдсан дагуу байгууллагын дотоод сургалтын төлөвлөгөөг боловсруулан баталсан. Эхний хагас жилийн төлөвлөгөөт 17 сургалт сэдвийн дагуу сургалтын материалыг бэлтгэн явуулж, мөн мэргэжлийн байгууллагууд болон аймгийн Нийгмийн даатгалын газар, Татварын хэлтэс зэрэг байгууллагуудтай хамтарсан сургалтад бүх аудиторууд бүрэн хамрагдлаа.

Аймгийн БСУГ-аас 2020 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр зохион байгуулсан аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн өмчийн бус бүх цэцэрлэгийн эрхлэгч нарын сургалт, семинарт оролцон, “Төрөөс сургуулийн



өмнөх боловсрол олгож байгаа өнөөгийн байдал, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн дэлгэрэнгүй мэдээллийг ахлах аудитор Л.Жаргалсайхан хийлээ.

Төв аймгийн боловсролын салбарын удирдах ажилтны үр дүнгийн гэрээг дүгнэх, удирдах ажилтны мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, давтан сургах чиглэлээр сургалт, семинар 2020.01.09-ны өдөр зохион байгуулагдаж Төв аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Саранчимэг санхүүгийн тайлангийн аудитын талаар тусгайлан хөтөлбөр бэлтгэж танилцуулга хийлээ.



Аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн захирлуудад 2018 оны санхүүгийн тайлангийн аудитын үр дүн, анхаарах асуудал, 2019 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад хэрэгжүүлэх ерөнхий чиглэл, зөвлөмж, судалгааг гаргаж ирүүлэх талаар болон байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтны анхаарах асуудлын талаар танилцуулж харилцан ярилцлаа.

**Долоо. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААР:**

Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НББОУС-уудыг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаа.

Батлагдсан төсвийн дагуу эхний хагас жилд 292.8 сая төгрөгийн санхүүжилт авахаас 249.6 сая төгрөг буюу 43.2 сая төгрөгийн санхүүжилт дутуу авсан байна. 2020 оны батлагдсан төсвийг төсвийн хуваарийн дагуу, сар бүр, эдийн засгийн ангилал бүрээр, зориулалтын дагуу зарцуулж 169 гүйлгээг хийж анхан шатны баримтыг бүрдүүлж ажиллаж байна

Нэмэлт санхүүжилтийн дансаар төвлөрсөн аудитын үйлчилгээний төлбөрүүдийг тухай бүр бүртгэж аудитын үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлсэн 3 аудитын компанид төлбөрийг гэрээний дагуу шилжүүлсэн. Мөн Төрийн аудитын тухай хуулийн шинэчлэн батлагдахтай холбоотойгоор 2021 оны төсвийн төслийг бэлтгэж, программд оруулж нэгтгүүлээ. Байгууллагын эхний хагас жилийн санхүүгийн тайланг гаргаж байна.

Байгууллагын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд гарган гэрээний дагуу “Грант Торнтон” Аудит ХХК-аар шалгуулж, “Зөрчилгүй” санал дүгнэлттэй шалгагдсан. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг гарган хүргүүллээ.

Нийгмийн даатгал, ХХОАТ-ын тайланг хуулийн хугацаанд нь гаргаж өр авлага үүсгэлгүй ажиллаж, албан хаагчдын нийгмийн даатгалын дэвтэрт сар бүр бичилт хийж нийгмийн даатгалын байгууллагаар баталгаажуулан ажиллаж байна.





**Найм. ДҮГНЭЛТ, САНАЛ:**

Төв аймаг дахь Төрийн аудитын газар нь Төрийн албаны тухай хуулийн 54, 55 дугаар зүйл заалт, Монгол улсын Засгийн газрын 2019 оны 37, 38 дугаар тогтоол, МУЕА-ын 2020.02.18-ний өдрийн “Журам батлах тухай” А/20 тоот тушаалыг үндэслэн 2020 оны байгууллагын болон Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан баталгаажуулж, улирал бүрд хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

2020 онд хэрэгжүүлэх аудитын болон гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 бүлэг 62 арга хэмжээтэйгээр боловсруулан эхний хагас жилийн байдлаар хэрэгжилтийг гарган хүргүүлсэн.

Эхний хагас жилийн байдлаар гүйцэтгэлийн болон аудитын төлөвлөгөөний дагуу санхүүгийн 370, нэгдсэн удирдамжаар гүйцэтгэлийн 1, нийцлийн 2, аймгийн ИТХ-ын захиалгаар гүйцэтгэх нийцлийн 1, өөрийн санаачилгаар гүйцэтгэлийн 1 нийт 375 аудитыг 100 хувь гүйцэтгэж, 2 нийцлийн аудит гүйцэтгэлийн үе шатанд хийгдэж байна.

Тайлант хугацаанд гүйцэтгэсэн санхүүгийн, гүйцэтгэлийн, нийцлийн аудитаар нийт 76,291.4 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс санхүүгийн тайлангийн аудитын явцад 19,762.8 сая төгрөгийн зөрчлийг залруулж, 203.6 сая төгрөгийн төлбөрийн акт, 29,241.5 сая төгрөгийн албан шаардлага бичиж, 26,805.1 сая төгрөгийн 581 зөвлөмж хүргүүлж, 221.7 сая төгрөгийн зөрчилд 26 албан тушаалтанд хариуцлага тооцуулах, 56.8 сая төгрөгийн 2 зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлээд байна.

2020 оны эхний хагас жилийн санхүүгийн, гүйцэтгэлийн, нийцлийн аудитаар илэрсэн нийт алдаа зөрчлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 82,720.8 сая төгрөгөөр буюу 52,1 хувиар буурсан эерэг үзүүлэлттэй байна. Энэ нь Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудиторуудын гүйцэтгэсэн аудит, хэрэгжүүлсэн ажлуудын бодит үр дүн юм.

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР...../Ц.ХИШИГЖАРГАЛ/

БОЛОВСРУУЛСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР...../Т.МАЙЦЭЦЭГ/